



**СЭКЕРРЕСОРСУС
МОНГОЛИА**

Батлав: БОАЖЯ-ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА (А. ЭНХБАТ)

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“СЭКЕРРЕСОРСУС МОНГОЛИА” ХХК-ийн ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
ЗАХИРАЛ (М. БАЯРМАНЛА)



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЧАНДМАНЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ ЗЭЭГТИЙН
УУРХАЙН MV-000905, MV-011965, MV-014217, MV-017438 ТООТ АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хянасан: БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын ахлах
шинжээч (Ц. Жаргалнэмэх)

Боловеруулсан: “Сэкер Ресорсус Монголиа” ХХК-ийн
Байгаль орчны мэргэжилтэн *Б. Дэлгэрэх* (Б. Дэлгэрэх)

2023 он

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА
1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч мэдээлэл.....	2
1.2. Технологийн товч тайлбар, технологийн үйл ажиллаганы бүдүүвч схем.....	3
1.3. Төсөлд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн жагсаалт.....	4
1.4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө.....	5
1.5. Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал.....	5-8
1.6. Усны хэрэглээ.....	8

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	
2.1.1. Агаар.....	8-9
2.1.2. Хөрс.....	9-10
2.1.3. Ус.....	10
2.1.4. Амьтан болон ургамал.....	10-11
2.2. Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, давтамж, нөлөөлөл, үргэлжлэх хугацаа.....	11-12

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

3.1. Тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	12-13
--	-------

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	14-15
4.2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	15-16
4.3. Усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	16-17
4.4. Ургамлын аймаг, ургамалан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17-18

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....18
6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....18-19
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....19
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....19-20
9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....20
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....21
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....22-23

11.1. Хөрсний хяналт шинжилгээ	
11.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ	
11.3. Усны чанарын хяналт шинжилгээ	

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....24-26
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....27-28

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч мэдээлэл

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК нь Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутагт орших Шар хоолой хэмээх нэртэй газарт ашигт малтмал ашиглалтын MV-000905, MV-011965, MV-014217, MV-017438 - тоот тусгай зөвшөөрөл бүхий 483.53 га талбайг эзлэн байрлана. Орд нь Алтайн нурууны зүүн өмнөд талын салбар Гичгэний нурууны уулс хоорондын хотгорын нэг болох Шар хоолойн хотгорт далайн түвшинээс дээш 2300 гаруй метрийн өндөрт байрлана.

Тус уурхай нь 1979 оноос ашиглалт явуулж ирсэн бөгөөд 1994 онд хувьчлагдан 2006 оноос манай компани тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажилагаа явуулж байна. Анх 1969 онд Зээгтийн нүүрсний ордод эрэл хайгуулын ажил явуулсан. (Д.Дашцэрэн нар) Энэ үед 7 канав, 20 шурф, 18 цооногийн өрөмдлөгийн ажил хийсэн байна.

1979 онд Д.Оросоогийн удирдсан анги ордод нарийвчилсан хайгуул хийсэн. Нарийвчилсан хайгуулаар 10 канав, 133 шурф (116 шурфыг нөөцийн тооцоонд ашигласан), 54 цооногийн өрөмдлөг (50 цооногийг нөөцийг тооцоонд ашигласан)-н ажил хийж, балансын нөөц болон урьдчилан үнэлсэн, таамаг нөөцүүдийн тооцоо хийжээ.

Үүнээс хойш тус ордод нарийвчилсан ба ашиглалтын хайгуулын нэмэлт ажил явагдаагүй ба 2005 онд “Түлш-Алтай” ХХК-тай байгуулсан менежментийн гэрээний дагуу 2006 оноос “Гоби Коул энд Энержи” ХХК нөөц өсгөх нарийвчилсан хайгуулын ажлыг хийж эхэлсэн.

Зураг №1.Талбайн байршил



“Сэкер Ресорсус Монголиа” ХХК -нь Байгаль орчныг хамгаалах талаар Монгол улсын хууль тогтоомж, стандартуудыг даган мөрдөж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ)-д тусгагдсан зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэн төслийн үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх зорилготойгоор ажиллаж байна.

2012 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, 2013 онд Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг ашиглалтын талбайнуудад эрх бүхий мэргэжлийн байгууллагаар шинэчлэн боловсруулуулж холбогдох байгууллагаар батлуулсан.

Мөн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу 2011 оноос эхлэн археологийн хайгуул судалгаа, 2012 онд археологийн малтлага судалгааны ажлуудыг шат дараатайгаар хэрэгжүүлсэн.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр болон биелэлтийг БОАЖЯ-аар жил бүр батлуулж, мөрдлөгө болгон ажиллаж байна.

1.2. Технологийн товч тайлбар, технологийн үйл ажиллаганы бүдүүвч схем

Одоогоор Зээгтийн уурхай нь Говь-Алтай аймаг болон сум, орон нутгийн дулааны хэрэгцээнд зориулж бага хэмжээний нүүрс олборлож байна. Хөрс хуулалт болон нүүрс олборлолтод ойролцоогоор 1-1.5м³ шанаганы багтаамжтай экскаватор сонгон ажиллуулдаг тул нүүрсний доголын өндөр 3 метр, орлын өргөн нь 10-15 метр байна.

Ажлын талбайн өргөн

$$B_{am}^o = B_n + c_1 + T_z + c_2 + z = 16.5 + 2 + 15 + 2 + 0.51 = 36.01 \text{ м}$$

Үүнд: B_n – нурлын өргөн, м

c_1 – нурлын ирмэгээс машин замын ирмэг хүртэлх зай, м

T_z – замын өргөн, м

c_2 – аюулгүйн зай, м $c_2 = 2\text{м}$

z – нурлын призмын өргөн, м

$$z = H_o \cdot (\text{ctg } \alpha_o^m - \text{ctg } \alpha_o) = 5 \cdot (\text{ctg } 65^\circ - \text{ctg } 70^\circ) = 0.51$$

Уурхайн тоног төхөөрөмжийн иж бүрдэл

Уулын ажилд Эксватор-автосамосвалын иж бүрдэлтэйгээр гадаад тээвэртэй ашиглалтын системээр ажиллана. Уурхай I болон IV улиралд ажилладаг ба шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг тухай бүрд нь түрээсээр авч ажиллуулах ба түрээсийн төлбөр, дизель түлшний зардлаас бусад сэлбэг хэрэгсэл, элэгдлийн зардал нь түрээслэгч тал хариуцах болно.

1.3. Сүүлийн жилүүдэд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн жагсаалт

Тус уурхай нь 1979 оноос тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа Зээгтийн уурхайгаас ойролцоох сумдууд нүүрс авах зайлшгүй шаардлагатай учир түрээсийн техник, тоног төхөөрөмжөөр нүүрс олборлон нийлүүлж байна.

Хүснэгт-1. 2023 онд уурхайд ажиллах техник тоног төхөөрөмжийн бүтээл

Нэр	Марк	Хүчин чадал	Тоо.ш	Ээлж бүт м ³	Сар бүт м ³
Экскаватор	CAT325D	125 kW	1	1,500.0	45000
Автосамосвал	20 тн	6200/V8	3	500.0	45.000
Ачигч	LV-60N6-50	18 kW	1	1.200	45000

1.4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө
Нүүрс олборлолт

Хөрс хуулалт болон нүүрс олборлолтын ажлыг 2023 онд ордын нүүрсний гарцын суналын дагуу өмнө үүссэн уурхайн карьерийг үргэлжлүүлэн явуулахаар төлөвлөв. 2023 оны 10 дугаар сард 5.0 мян.м³ хөрс хуулж, 3.0 мян тонн нүүрс олборлохоор төлөвлөлөө.

Нүүрс борлуулалтыг орон нутгийн байгууллагуудын хэрэгцээний үе буюу хүйтний улиралд 10-12 дугаар сар болон дараа оны 1 дүгээр сараас 3 дугаар сарын хооронд хийнэ. Нүүрс олборлолтын ажлыг зөвхөн зээгт давхраас дээр ашиглалтын 905А талбайд явуулна.

Хөрс хуулалт

Хуулсан хөрсийг дунджаар 1.8 км зайд автосамосвалаар тээвэрлэж гадаад овоолгод буулгана. 2022 онд нүүрсний хаягдлыг бууруулах, сум, орон нутгийн жижиг хэрэглэгчдийг чанар сайтай ангилан ялгасан нүүрсээр хангах зорилгоор агуулагч чулуулаг болон нүүрсний давхарга дундын завсрын бохирдуулагч үенцэртэй нүүрснээс гар ялгалт хийж 2000 тонн нүүрсийг хэрэглэгчдэд нийлүүлэн хаягдал бохирдолтын хэмжээг багасгаж байгаа бөгөөд 2023 онд мөн үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна.

Хайгуул өрөмдлөг

2023 онд хөрс хуулалтын ажил явагдахгүй ба орон нутаг болон Чандмань сумын дулааны хэрэгцээнд зориулан нүүрс олборлон гаргахаар төлөвлөсөн болно. Гиймээс орон нутаг болон сумын дулааны хэрэгцээний нүүрсийг уурхайн авахад бэлэн нүүрсний мөрөгцөгөөс хангах ба тэсэлгээтэй хөрс хуулалтын ажил хийгдэхгүй.

1.5. Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал
Физик газар зүй


Орд нь Алтайн нурууны зүүн өмнөх талын салбар уулс болох Түгээн, Хар-Аргалантын нуруудын хооронд орших Бигэрийн хотгорт оршино. Орд нь 2300 гаруй метрийн өндөрлөгтэй (далайн түвшнээс дээш) гадаргуу бүхий талбайг эзэлнэ. Чулуун нүүрсний Зээгтийн орд нь Алтай хотоос 250 км, Чандмань сумаас баруун хойш 8 км зайд оршино. Ордод ойр байрлах хилийн боомт нь БНХАУ-д нэвтрэх Говь-Алтай аймгийн Бургастайн боомт 230 км-т, Шивээ Хүрэнгийн боомт 300-350 км зайтай тус тус оршино. Газарзүйн байршлын солбицол:

ХӨ 42¹ 2¹ 50¹¹ - 45¹ 22¹ 50¹¹

ЗУ 97¹ 51¹ 30¹¹ - 97¹ 54¹ 30¹¹

Физик газарзүйн мужлалаар уг талбай нь Алтайн уулархаг их мужийн Говь-Алтайн бүсэд багтдаг. Баруун хойноос зүүн урагшаа сунаж тогтсон Алтайн салбар уулс болох Гичгэний нурууны ард оршино. Уулс нь гүн сайр, жалгаар хүчтэй хэрчигдсэн байх ба талбайн өмнөд хэсгээр орших уулс нь голчлон эгц хажуутай, шовх оройтой, хойноосоо урагш чиглэлтэй гүн хавцал, жалгаар хүчтэй хэрчигдсэн байдалтай. Түүний заримаар нь авто машин, ердийн хөсгөөр нэвтрэх боломжтой. Талбайн үнэмлэхүй өндөр нь урдаасаа хойшлох тусам өндөрсөх хандлагатай. Үнэмлэхүй өндөр нь дунджаар 2200-2500 м байна.

Зураг№3. Байгалийн бүс бүслүүр эко систем



Уур амьсгал

Эх газрын эрс тэс уур амьсгалтай. Жилийн дундаж температур $-1,8$ -аас $+3,4$ $^{\circ}\text{C}$ -г хэлбэлзэнэ. Хүйтний улирал үргэлжлэх хугацаа 6 сар ба түүнээс дээш. Гэхдээ 10-р сараас 4-р сар хүртлэх хасах температуртай байдаг. Өвөл хамгийн багадаа буюу $-22,3$ $^{\circ}\text{C}$, дунджаар -31 $^{\circ}\text{C}$ байна. Тунадас 150-200 мм, өвөл -31 $^{\circ}\text{C}$ дундаж температуртай, зун хамгийн их буюу $+30$ $^{\circ}\text{C}$ орчим байсан гэж тэмдэглэгджээ. Хамгийн халуу үе 7-р сард $+26$ $^{\circ}\text{C}$ дундаж температуртай байна. Зун зарим өндөр уулсынхаа оройгоор цас хайлалгүй жил өнжих нь ч бий. Тунадасны хэмжээ олон жилийн дунджаар 48,6-214,8мм. Сарын дундаж чийглэг 28-29%, жилийн дундаж чийглэг 70% байдаг. 4, 5-р сард 25м/с хүртэл хурдтай хүчтэй шороон шуурга болдог.

Хөрс

Тусгай зөвшөөрөлтэй ашиглалтын талбайд цайвар хүрэн хөрсний хэв шинж тархах бөгөөд Монгол орны хөрс газарзүйн мужлалаар говийн их мужийн Монголын өрнөд мужийн Бигэр-Баянголын 30-р тойрогт хамрагдана.

Дутуу хөгжилтэй цайвар хүрэн хөрс Тусгай зөвшөөрөлтэй талбайд гүвээ толгодын орой болон ар хажуу хэсгээр ихэвчлэн тархана. Хатуу суурь чулуулгын элювийн хурдас дээр тогтворжих бөгөөд хэмхдэс сайр чулуу ихтэй байдаг онцлогтой.

Цайвар хүрэн хөрс Лицензтэй талбайн дийлэнх хэсгээр тархах бөгөөд гол онцлог нь гадаргын хувьд харьцангуй тэгшивтэр газруудад тархана. Хөрсний гадаргын ихэнх хэсэг ургамалгүй байдаг учраас салхины үлээгдэлд хялбар өртөж том шихэгтэй элс, жижиг сайр чулуугаар бүрхэгдсэн байна.

Далд глейрхэг (нугархаг) цайвар хүрэн хөрс Энэ хөрс нь талбайн ухаа толгодын хоорондох хотгор газрыг дагаж тархах бөгөөд үетэн алаг өвст ургамал бүрхэц энд 50-60 хувь хүрнэ. Энэ хөрсөнд орчин тойрны өндөрлөг газраас гадаргын урсацаас ирж хуралдах эс чийгийн нөлөөгөөр улирлын чанартай түр зуурын нэмэгдэл чийг бий болж нугархаг шинж үүсэх нөхцөл бүрддэг байна.

Эртний цэвдэгийн үлдмэл шинжтэй хар хүрэн хөрс Энэ хөрс нь лицензтэй талбайд нүүрсний карьерын орчимд гүдгэрдүү газрын оройгоор багахан хэмжээний талбай эзлэн тархсан байна. Эртний цэвдэгт үзэгдлийн ул мөр болох шаантаг хэлбэртэй, ихэнхдээ карбонатгүй бага зэрэг ялзмагжсан нунтаг шороогоор дүүргэгдсэн. Энэхүү эртний цэвдэгийн үлдмэл шинж морфологийн хувьд хадгалагдаж хөрсөн бүрхэвчийг алаг цоог шинжтэй болгож байна.

Ургамал

Судалгаагаар Зээгтийн нүүрсний уурхайн урд талд Монгол Алтайн нурууны төгсгөл болох Эмээлцэгийн нуруу, Гичгэний нуруу зэрэг уул, нуруудын оргил хэсгээр тархах өндөр уулын хуурай хээрийн жижиг дэгнүүлт үетэн-бушилзат, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвс-бушилзат түгээмэд тохиолдоно. Эмээлцэгийн нурууны ар хөндийд нам уулсын уулын хээрийн элдэв өвс-хялганат, тэгш тал хөндийд элдэв өвс хялганат, ерхөг-хялганат дунд зэрэг талхлагдсан бүлгэмдэл зонхилон тархана.

Мөн нуурт хонхор, давсархаг газрын ургамалжилт тохиолдлоо. Өндөр уулын хээрийн бүсийн цайвар хүрэн хөрстэй газар *Stipa gobica*, *Stipa glareosa*, *Gleistogenes squarrosa*, *Agropyron cristatum*, *Allium polyrhizumol* бүлгэмдэл, цав толгодоор чулуусаг алаг өвснөөс бүлгэмдэл үүсэн тархана. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн нийт хэмжээнд 17 овог 36 төрөлд хамаарагдах 44 зүйл ургамал бүртгэгдлээ. Овгуудын дотроос үетэн 2 зүйл, нйилмэл цэцэгтэн 8 зүйл, луультаан 6 зүйлтэйгээр бусад овгийн ургамал 1-3 зүйлтэй тохиолдож байна. Түүнчлэн зүйлүүдийн дотроос 3 заримдаг сөөгөнцөр, 13 зүйл нэг наст ургамал байгаа бөгөөд 28 зүйл үлүн наст ургамал ургаж байна. Эмийн болон ашигт ургамал 19 зүйл бүх ургамалууд хадлан бэлчээрийн ач холбогдолтой. Тухайн нутгийн цаг уур, хөрсний онцлогоос хамаараад ургамлын нягтрал багатай, их сийрэг тачир. Ургамалшилт нь хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. Энд агь, таана, мангир, хөмүүл, хазаар, баглуур зэрэг олон наст ургамал, бударгана, харгана гэх мэтийн модлог, бутлаг говийн ургамал ургадаг. Хавар 4-р сараас ургамал ургаж цэцэг, навчаа дэлгэж эхлэх ба намар 9-р сараас гандах байдалтай болж ирнэ.

Ан амьтан

Чандмань сумын нутагт байрлах талбайн байгалийн хэв шинж нь мөлхөгч амьтын олон зүйл байрших тохиромжит нутаг юм. Тус талбайд сээртэн амьтаас загас, хоёр нутагтны ангийн төлөөлөгч тархацын хүрээнд тэмдэглэгдээгүй болно. Ашиглалтын талбай түүний орчим нутгийн шувуудын зүйлийн бүрдэл нь амьдрах орчны хэв шинж, улирлын ялгаатай байдал зэрэг биологийн хүчин зүйлээс хамаарч суурин үүрлэж, өндөглөдөг, мөн зөвхөн нүүдлийн үед дамжин өнгөрөх тул тоо толгой зүйлийн баялаг харилцан адилгүй. Тухайн район нь ан амьтадаар нилээд баялаг, уул, асга,

хадандаа аргаль угалз, янгир, ирвэс байдаг. Араатан амьтдаас үнэг, хярс, мануул, цөөн тооны чоно, мэрэгчдээс үлийн цагаан оготно, ольби, орог саарал, шар сүүлт, алаг даага, туулай зэргийг нэрлэж болно. Жигүүртэн амьтдаас бүргэд, тас, элээ, хэрээ, харцага, идлэг шонхор, шар шувуу, сар, болжмор, ногтруу, ууль, тагтаа, чогчиго, хуланжороо зэргийг нэрлэж болно. Хэвлээр явагчдаас могой, замба, хонин ба могой гүрвэлүүд, шавьж болон жижиг далавчитнаас арваалж, аалз, голио, царцаа зэргийг нэрлэж болно.

1.6. Усны хэрэглээ

Зээгтийн уурхай нь 2023 онд улирлын чанартай тул IV дүгээр улиралд 10-15 хоногийн хугацаанд ажиллах бөгөөд ахуйн зориулалтаар ашиглах тул усны дүгнэлт аймгийн Байгаль орчны газраар гаргуулан сумын Засаг даргатай ус ашиглах гэрээ байгуулан ажиллана.

Технологийн зориулалттай ус

Хөрс хуулалт өвлийн улиралд явагдах тул технологийн зориулалттай ус ашиглахгүй болно.

Ус шүүрүүлэлт

Зээгтийн уурхайн нь одоогоор харьцангуй бага гүнд (25м орчим) ашиглалт явж байгаа учир гүний усны түвшинд хүрээгүй байна. Ордын хэмжээнд гидрогеологийн нарийвчилсан хайгуулын ажил хийгдэсэн боловч уурхай ахуйн хэрэглээний усаа сумын төвийн худгаас зөөвөрлөн хэрэглэж байна.

Ахуй хэрэглээний ус

Уурхайн ахуйн хэрэглээний усыг уурхайгаас 9 км-ийн зайд орших Чандмань сумын төвийн худгаас зөөж хэрэглэнэ. Уурхайн ажлын явцад дунджаар 5-6 хүн уурхайн тосгонд байрлаж өдөрт 120-150 литр ус хэрэглэх ба нүүрс борлуулалтын сарын хугацаанд нийт 2,5 тонн ус хэрэглэнэ гэж тооцов.

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

2.1.1. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

Цаг агаарын хуурай хуурайшилттай болон шуургатай өдрүүдэд уурхайд тэсэлгээ хийх, нүүрс олборлох болон тээвэрлэх үед тоос, хорт хий, уулын машин механизм, тоног төхөөрөмжийн дуу чимээгээр агаарын физик бохирдолт явагдаж болзошгүй, мөн тэсэлгээний үед болон шатах тослох материалын машин механизмын яндангаар хаягдах хорт хий хаягдах, химийн бодисын болон хатуу хог хаягдал зэргийн болзошгүй нөлөөгөөр агаар химийн нөлөөлөлд орох зэргээр давхардмал нөлөөлөлд орох магадлалтай. Уурхайн хаягдлын овоолго, нүүрсний овоолгын хэсгүүдээс салхиар дамжин агаарт тоосжилт үүсэх, автомашины хөдөлгүүрээс гарах утаа агаарын чанарын нөлөөлөл үүсгэж болзошгүй.

Агаар орчны бохирдолт:

- Хөрс хуулалт
- Нүүрс олборлолт
- Овоолго

Нөлөөлөлд өртөх объект

- Уурхайн түр хээрийн анги орчим
- Шинэжинст сум, багийн оршин суугчид
- Амьтан
- Ургамал

Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- Агаар дахь тоос болон хорт хийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- Тоос 0.5 мг/м³
- Нүүрстөрөгчийн дутуу исэл 5.0 мг/м³
- Альдегид 0.035-0.5

Ажиглалт, хяналт явуулах шаардлага

- Мэргэжлийн байгууллагаар агаарын сорьц дээж авхуулах, шинжилгээ хийлгэнэ.
- Мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвийн эмч нарын үзлэгт бүх ажиллагсдыг хамруулна.
- PM_{2.5-10} тоосжилтийн хэмжилт хийх

2.1.2. Хөрсний чанарт үзүүлэх нөлөөлөл

Хөрс, газрын гадарга нь уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас талхлагдах, элэгдэх эвдэрхийн зэрэгцээ тоос, хатуу шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдож болзошгүй. Мөн хөрс хуулалт болон төслийн үйл ажиллагааны явцад хөрс эвдрэлд орохын зэрэгцээ үржил шимээ алдах сөрөг нөлөөлөл байна.

Хөрсний бохирдол

- Ашиглалтын явцад хөрсний физик-механикийн болон химийн макро ба микро элементүүдэд өөрчлөлт орсон
- Хөрсний элэгдэл болон эвдрэл үүссэн
- Уурхайн малталт болон гадаад овоолгын суурийн талбайд шимт хөрс өртсөн
- Хүнд даацын машин, механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээсэн
- Хатуу болон шингэн хог хаягдлын улмаас хөрсөнд бохирдол үүссэн

Нөлөөлөлд өртөх объект

- Шимт хөрс бүхий газар
- Малын бэлчээр
- Амьтан ургамал

Стандарт, нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- БОЯ,ЭХБ-ны сайдын 1997 оны 143/А, 352/А тоот тушаалын 2,3,5-р хавсралт

Ашиглалт явуулах шаардлага

- Газрын төлөв байдал, хөрсний чанарын дээжийг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.
- Уулын ажлыг зөвхөн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.

2.1.3 Усны чанарт үзүүлэх нөлөөлөл

Газрын гадаргын болон газрын доорх усан орчин бохирдсон нөхцөлд тэр нь хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлж болзошгүй. Газрын доорхи усны ашиглалтаас усны нөөц багасах, усны түвшин буурах зэрэг нөлөөлөл үүсэж болзошгүй.

Гадаргын ба гүний ус

- Гадаргын ба гүний усанд одоогоор нөлөөлөл багатай

Нөлөөлөлд өртөх объект

- Хүн ба Мал
- Амьтан ургамал

Стандарт, нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- БОЯ, ЭМНХЯ-ны сайдын 1997 оны 143/А тоот тушаалын 2,3,5-р хавсралт
- Гадаргын усны цэврийн ангилал

Ажиглалт явуулах шаардлага

- Ундны усны хяналт баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

2.1.4 Амьтны болон ургамлын аймагт үзүүлж болзошгүй нөлөөлөл

Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа, хөрс хуулалт, автомашины хөдөлгөөн зэргээс ургамал талхлагдах доройтох зэрэгцээ тоос, ахуйн хатуу, шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдож ургамлан бүрхэвч багасах нөлөөлөл үүснэ. Уурхайн үйл ажиллагааны дуу чимээ, автомашины хөдөлгөөн зэргээс шувууд, амьтад уурхайн талбай болон ойр орчмын талбайгаас дайжих нөлөөлөл үүснэ.

Болзошгүй нөлөөлөлийн эх үүсвэр

- Уулын бэлтгэл ажлууд
- Уурхайн хөрс хуулалт ба карьер
- Өрөмдлөг, тэсэлгээ
- Олборлолт / нүүрс ачих тээвэрлэх /
- Хаягдал аж ахуйн /нүүрсний хаягдал, хаягдлын гадаад, дотоод овоолго /
- Талбайн гадаргын ус зайлуулах систем

- Шатах тослох материалын агуулах, шатахуун түгээх станц
- Зам, тээвэр
- Бохир ус цэвэрлэх байгууламж
- Хүн, машин механизм хөдөлгөөн

Нөлөөлөлд өртөх объект

- Уурхай орчмын ургамал амьтан

2.2 Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, давтамж, нөлөөлөл, үргэлжлэх хугацаа

Зээгтийн нүүрсний уурхайн төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдал, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, түүний эрчимшлийг тодруулахын тулд Леопольдын матрицын аргыг ашиглав.

Хүснэгт 2. Леопольдын матрицын аргаар тооцсон нөлөөллийн үнэлгээ

Төслийн бүрэлдэхүүн	Барилга байгууламж барих үеийн барилгын материалын хаягдал	Химийн бүтээгдэхүүн /будаг, эмульс, шохой, цемент гэх мэт/	Авто тээврийн хэрэгсэл олширох	Ой, хээрийн түйиэр	Хүмүүсийн бөөгнөрөл	Хатуу хог хаягдал	Шингэн хаягдал	Ил задгай гал түлэх	Бүгд
Агаарын бохирдол	+	+	+	+	-	++	+	+	8
Хотгор гүдгэрийн төрх	+	-	+	-	-	+	-	-	3
Гадаргын усны бохирдол	-	++	+	+	++	++	++	-	11
Газрын доорхи усны бохирдол	-	++	+	-	+	++	+++	-	9
Хөрс	++	+++	++	+++	+++	++	++	+	17
Ургамлан бүрхэвч	+	++	++	+++	+++	++	+	++	
Амьтны аймаг	-	+	++	++	+	+	+	+	
Шавьж бичил биетэн	+	++	+	++	+	++	+	+	
Усны нөөц	-	+	-	-	-	-	-	-	

Дээрх үнэлгээнээс харахад тус нүүрсний орд нь уурхайн ашиглалтын үеийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хэмжээ их, тэдгээр нь өөр хоорондоо харилцан

уялдаатай, нэг нь нөгөөдөө шууд болон дам байдлаар нөлөөлөх нь харагдаж байна. Гэхдээ энэхүү нөлөөллүүд дотор онц уршигтай сөрөг нөлөөлөл байхгүй. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгээс хөрс эвдрэх, ургамлан бүрхэвч талхлагдаж төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох, хүн ам, машин техникийн бөөгнөрөл дуу чимээнээс ан амьтан үргэж дайжих зэрэг сөрөг нөлөөлөл үүсч болох магадлалтай.

Гео орчин

Уурхайн малталт, тээвэрлэлт барилга байгууламж барих, угсрах суурьшил болон суваг шуудуу татах, нүх цооног ухах зэрэг газар шорооны бүх ажлаар тарчиг сийрэг, төрөл зүйл цөөн ургамалтай энэ газрын хөрс ургамлан нөмрөг эвдэрнэ. Нуралт, гулсалт, суулт үүсэж болох догол мөрөгцөгүүдтэй уурхайн малталтууд, өвс ургамалгүй элэгдэж талхлагдсан элс шороон зам, талбай бий болно. Мөн хөрс хуулалтын хоцрогдлоос шалтгаалан доод түвшингүүдийн зарим хэсэг дэх хажуугийн налууугийн ерөнхий өнцөг 45° –аас дээш болох тохиолдол гардаг нь гулсалт нуралт болох аюулд хүргэж болзошгүй юм.

Гадаргын ба газрын доорх ус

Чулуун нүүрсийг ил аргаар олборлох хэвийн нөхцөлийн хангах, нүүрсний чанарын сайжруулах зорилгоор түүний чийгийг багасгах, олборлолтын явцад уурхайн малталтын хана, ёроолоос шүүрэх хөрсний усыг гадагш насосоор татаж зайлуулна. Энэ нь аажимдаа газрын доорх ус буюу усны нөөцийн түвшинд нөлөөлөх магадлалтай.

Агаар орчин

Өрөмдлөг, тэсэлгээ, уурхайн малталт, гадаад овоолго, тээвэрлэлтийн зам, нүүрс олборлолт бутлалт, тээвэрлэлт, суурьшил хөдөлгөөнөөр элэгдэж, талхлагдсан хөрс газар болон технологийн бүх үйл ажиллагаатай холбогдож агаар орчин бохирдоно.

Хөрс, ургамал, биологийн төрөл зүйл

Төслийн талбай түүний ойр хавийн хөрс нүүрс олборлолтоор эвдрэх, элэгдэж талхлагдах нь ургамлын аймгийн зүйл төрөл доройтох, ургамлын бүрхэц ядуурах, өсөлт хөгжилт муудаж ургац буурах, шинэ орчинд зохицсон хөл ургамлын зүйл төрөл ургах зэрэг сөрөг нөлөө гарна. Ургамалшилтад нөлөөлөх өөр нэг хүчин зүйл бол орчны хөрсний ус чийгийн дутагдал юм. Хур тунадас багаас орчны чийг хангамж багасах, гүний усны түвшин буурч, гадаргын урсац ширгэж үгүй болох зэргээс хөрсний үржил шим, ус чийг багасна. Энэ нь ургамлын бүрхэц буурах, төрөл зүйл цөөрөх нэг шалтгаан болно.

Нүүрсний ордыг ил аргаар олборлон ашиглах үед уурхайн малталт болон зам талбайд хөрс, ургамлын хамтаар амьтны аймаг ялангуяа шавьж хорхой үе нугаламгүй амьтад, шавьж идэштэн хийгээд бичил амьтад устаж үгүй болно.

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

3.1. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК -нь байгаль орчныг хамгаалах талаар Монгол улсын хууль тогтоомж, стандартуудыг даган мөрдөж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ)-д тусгагдсан зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэн төслийн үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилготойгоор ажиллаж байна.

Тус уурхай нь санхүүгийн байдлаас хамаарч зөвхөн орон нутгийн хэрэгцээнд зориулж ажиллаж байгаа тул 2023 онд өргөн цар хүрээний ажил төлөвлөөгүй болно.

Мөн Монгол Улсын хууль тогтоомж, стандартад нийцүүлэн байгальд ээлтэй орчин үеийн технологи нэвтрүүлэх, байнгын хяналт, мониторинг хийх, олборлолтын бүхий л үе шатанд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны стандартуудыг хэрэгжүүлэх замаар байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хангасан байгаль орчны зохистой бодлого барин ажиллаж байна.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд агаарын чанарт нөлөөлөх үйл ажиллагаануудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал: Хүнд машин механизм, бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, нүүрс болон хаягдал чулуулгын овоолгууд, ил уурхай, тээвэр, түлшний хэрэглээ зэргээс агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй. Эдгээр эх үүсвэрүүдээс хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 3. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Нүүрс олборлолтын үед Замаас үүсэх тоосжилтыг бууруулах- хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ. (Хурдын хязгаарын тэмдэг тэмдэглээг байршуулан хяналт тавих)	Уурхайн талбайн дотоод болон талбайн гадна ашиглагдаж буй замууд	Тэмдэг тэмдэглэгээ	6-с доошгүй	300,000₮	Жилийн турш	“Агаарын тухай” хууль болон “Агаарын бохирдолын тухай” хууль, MNS4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”
2.		Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмаас ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах- Уурхайн олборлолтын үед туслан гүйцэтгэгч компанийн бүх тээврийн хэрэгсэл,	Уурхайн олборлолтын үед ажил гүйцэтгэх гэрээт компаниудын тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм	Засвар үйлчилгээ	Тодорхойлох боломжгүй	Гэрээний дагуу-Гэрээт компани хариуцах	Хуваарийн дагуу	

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Зээгтийн уурхай 2023 он

	Тээврийн хэрэгсэлийн яндангаас утаа болон хорт хий ялгарч агаар орчныг бохирдуулж болзошгүй нөлөөлөл	хүнд машин механизм, техникийг холбогдох үзлэгт хамруулсан, засвар үйлчилгээ хийсэн байх шаардлагыг ажил гүйцэтгэх гэрээнд зааж, хяналт тавьж ажиллана.						“Агаарын тухай” болон “Агаарын бохирдолын төлбөрийн тухай” хууль,
3.		Компанийн уурхайд ажиллах техник хэрэгсэлүүдийг тогтмол үзлэгт хамруулан, засвар үйлчилгээг тогтмол хийсэн байна.	Уурхайн дэд бүтцийн шугамын дагуу ашиглагдаж байгаа нийт тээврийн хэрэгсэл	Засвар үйлчилгээ	4	Үйл ажиллагааны зардлаар	Жилийн турш	
4.	Нүүрс тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, агаарын бохирдол үүсэх	Дулааны станц, бусад сумдад нийлүүлэх нүүрс тээвэрлэгч тээврийн машиныг бүтээлгэтэй байх шаардлагыг борлуулалтын гэрээнд тусгаж хэрэгжилтэнд хяналт тавина.	Нүүрс тээвэрлэлтийн зам дагуу	Тээвэрлэлтийн тоо	Тодорхойлох боломжгүй	Гэрээт компанийн зардлаар	Жилийн турш	“Агаарын тухай” хууль MNS4585:2007 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”
Нийт						300,000		

4.2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Ирэх 2023 онд байгаль орчны холбогдох хууль тогтоомж, компанийн байгаль орчны бодлогийн хэрэгжилтийг ханган, хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 4. Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Хөрсөн бүрхэвчийг хөндөж хуулах хадгалах	Аливаа газар хөндөлтийн үйл ажиллагааны өмнө шимт болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, тогтоосон хэмжээнд хуулж хадгална. (Газар хөндөлтийн үйл ажиллагаа явуулахгүй байх магадлалтай)	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Хөрс хуулах зөвлөмж олгосон талбайн тоо хэмжээ	Газар хөндөх зөвшөөрлийн хүсэлт бүрт	Дотоод зардлаар	Жилийн турш	MNS5916:2008 газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадаглалт
2.		Шимт хөрсийг хадгалж хамгаалах	Уурхайн үйл ажиллагааны талбайн хэмжээнд	Шинээр шимт хөрсний овоолго үүсгэх	Шимт хөрсний хуулалт хийгдэх бүрт			
Нийт						-		

4.3. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн зүгээс усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах зорилгын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.

Хүснэгт 5. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Газрын доор усыг ашигласнаар	Ус ашиглах гэрээ байгуулж, ус ашиглалтын төлбөрийг	Уурхайн хүрээнд	Ашигласан усны хэмжээнээс хамаарч тооцно.				Усны тухай хууль болон

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Зээгтийн уурхай 2023 он

	усны нөөц хомсдох, усны нөөцөд	гэрээний дагуу тооцож, тогтоосон хугацаанд нь төлсөн байна.						холбогдох дүрэм журам
2	хохирол учирч болзошгүй	Ус ашиглах дүгнэлт гаргуулна. Дүгнэлтэнд зааснаас бусад зориулалтаар ашиглах, Усны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргахгүй байна.	Төслийн хүрээнд	Усны төлбөрт төлсөн мөнгөн дүн	Баталгаажсан усны тоолуурын заалт	300,000₮	Жилийн турш	
3.		Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулна.	Уурхайн ажилтнуудад		Сургалтанд хамрагдсан ажилтнуудын тоо	500,000₮	7-р сард	
4.	Ундны усны чанар алдагдах	Ундны усыг тогтмол хугацаанд шинжлэх	Уурхай, сумын хүрээнд	Усны хэмжсэн үзүүлэлт	2	200,000₮	Жилд 2 удаа	Усны тухай хууль, усан орчны чанарын үзүүлэлт
Нийт						1,000,000		

4.4. Ургамлын аймаг, ургамалан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Ирэх 2023 онд ургамлын аймаг, ургамалан нөмрөг, ховор ургамлын хамгааллын хүрээнд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн дараах ажлуудыг төлөвлөөд байна.

Хүснэгт 6. Ургамлын аймаг, ургамалан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Уурхайн үйл ажиллагаанд ухагдах, дарагдах,	Хүнд даацын машин, техник болон бусад тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар	Уурхайн хэмжээнд болон сумаас уурхай хүртэлх зам	Тэмдэглэгээ байршуулах	4	Дотоод зардлаар	3-дугаар улиралд	MNS5918:2008 эвдэрсэн газрыг ургамалжуулах

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Зээгтийн уурхай 2023 он

талбайн бүх ургамлан бүрхэвч устах	явуулах, олон салаа зам гаргахгүй байх, замыг тэмдэгжүүлэх ажлыг хийнэ.							Техникийн ерөнхий шаардлага, Авто замын тухай хууль
Нийт							-	

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зээгтийн уурхайн үйл ажиллагаа орон нутгийн хэрэгцээнд зориулж улирлын чанартай, бага хүчин чадлаар ажиллаж байна. Олборлолт явагдаж буй талбай нь 25 метрийн гүнтэй байгаа ба цаашид тус талбайд үргэлжлүүлэн олборлолт болон хөрс хуулалтын ажил хийгдэх тул нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй болно. Харин 2022 оны байгаль орчны менежментийн тайлангийн дагуу гүйцэтгэлийн үнэлгээ хийсэн ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу Тухайн аймаг сум орон нутагт хууль бусаар ашигт малтмал олборлолтонд өртөж эвдрэлд орж орхигдсон газрыг нөхөн сэргээх ажлыг (2 га-с доошгүй талбайд) хийж гүйцэтгэнэ.

6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дагуу “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2022 онд Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллах хиймэл нүүр (Тэргүүн тэргэл)-н ойр орчмын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 1,5 га хүртэлх талбайд 1,500,000 ширхэг хайлаас сонгон тариалсан. Энэ ажлын үргэлжлэл болгон 2023 онд дараах ажлуудыг төлөвлөөд байна.

Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод бут тарих, арчлах хамгаалах	2022 онд хашаалсан 1.5 га талбайн нөхөн тариалалтыг хийх ажлын хүрээнд 1000 ширхэг мод тарих ажлыг орон нутгийн мод үржүүлгийн газартай хамтран зохион байгуулна.	Чандмань сумын баруун талд байрлах хиймэл нуурын ногоон байгууламжийн хашаанд	1000	5000	5,000,000	2-р улиралд	Мод тарих үндэсний өдөр зарлах тухай
2.		1,5 га-д тарьсан модны арчилгаа усалгааг тогтмол хийх хариуцсан ажилтан	Тариалсан ногоон байгууламжинд	1700	150,000	Догоод зардлаар	Жилийн турш	

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Зээгтийн уурхай 2023 он

		томилж модны амьдралтыг 85%-д барьж ажиллана.						
Нийт						5,000,000₮		

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зээгтийн уурхайн MV-000905, MV-011965, MV-014217, MV-017438 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбай болон нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор айл өрх байхгүй тул энэ талаарх ажил хийгдэхээргүй байна.

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Соёлын өв гэдэгт орон нутагт ёс уламжлалын дагуу өв уламжлагдсан буюу түүхэн ач холбогдолтой, орон нутгийнхны нийтээр хүлээн зөвшөөрсөн биет болон биет бус өвийг хамруулан авч үздэг. Бид үйл ажиллагаагаа явуулж буй орон нутгийнхаа түүх, соёлын өвийг хамгаалахад хувь нэмрээ оруулах зорилгоор 2023 онд дараах ажлыг төлөвлөөд байна.

Хүснэгт 8. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх, түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Биет болон биет бус өв	Төслийн ажилтнуудад Орон нутгийн харилцааны болон Соёлын өвийн зааварчилгаа өгөх, дурсгалт зүйлс олдох үед мэдээллэх хадгалах арга зүйн зааварчилгаа өгнө.	Төслийн ажилтнууд, гэрээт байгууллагын ажилтнууд	Нийт ажилтнууд	-	Дотоод зардлаар	Жилийн турш	МУ-н Соёлын өвийн тухай хууль тогтоомж
2.		Зээгтийн уурхайн баруун урд зүгт байрлах “ААВ хөшөө”-ний дурсгалт газрын орчны тохижилтыг сайжруулна.	Түүх соёлын дурсгалт газар	1	1,000,000	1,000,000	Жилийн турш	
3.		Уурхайн бүсэд соёлын өв бүртгэгдсэн	Түүх дурсгал соёлын өв				Жилийн турш	

		тохиолдолд хамгаалалтанд авч ажиллана.							
Нийт						1,000,000₮			

9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Осол эрсдлээс хамгаалах ажлын ихэнх нь төслийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол, цаашлаад зэрлэг ан амьтдын ослоос урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зардал нь төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой. Химийн бодис үйл ажиллагааны хүрээнд ашиглагдахгүй. Ирэх 2023 онд дараах ажлуудыг төлөвлөн хийхээр ажиллаж байна.

Хүснэгт 9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Гал түймэр	Уурхайн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах боломжтой бүх арга хэмжээг авах галын хоруудыг бэлэн байлгана..	Уурхайн талбай дахь бүх барилга байгууламж	Шинээр суурилуулах, хугацаа дууссанг цэнэглэх	300,000	300,000	Жилийн турш	Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшигаас хамгалах тухай хууль
2.		Галын болон байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулна.	Нийт ажилтнууд болон гэрээт компанийн ажилтнууд	1	250,000	250,000	Жилийн турш	
3	ХАБЭА	ХАБЭА-н сургалтыг жилд 2 удаа зохион байгуулсан байна.	Нийт ажилтнууд болон гэрээт компанийн ажилтнууд	2	250,000	500,000	Жилийн турш	ХАБЭА-н тухай хууль, Компанийн

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Зээгтийн уурхай 2023 он

4		Гэрээт компанийн ажилтнуудад өдөр тутмын зааварчилгааг тогтмол өгнэ.	Нийт ажилтнууд болон гэрээт компанийн ажилтнууд	Тухай бүрд	-	-	Олборлолтын үйл ажиллагааны үеэр	холбогдох дүрэм журам
Нийт						1,050,000₮		

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментийг үр ашигтай явуулахад хог хаягдлын ангилан ялгалт нэн чухал бөгөөд хаягдлыг зайлуулах тохиромжтой зөв арга замыг тогтоож өгдөг. Ангилан ялгалтыг хог хаягдлыг эх үүсвэр дээр ба хог хаягдлыг хүлээн авах нэгдсэн цэг дээр явуулдаг. Эх үүсвэр дээрх хог хаягдлын ангилан ялгалтыг хялбар, үр дүнтэй байлгах зорилгоор хог хаягдлын төрлөөр хаягжуулсан савнуудыг шаардлагатай цэгүүд дээр байрлуулж ашиглана. Дахивар нөөц болох хог хаягдал, аюулгүй хог хаягдлыг тушаах компанитай гэрээ байгуулж ажиллана.

2023 онд хог хаягдалын менежментээ илүү сайжруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг төлөвлөөд байна.

Хүснэгт 10. Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдалын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн болон үйлдвэрлэлийн	Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдалыг ангилан ялгах савыг шинэчлэн байгаль орчинд нөлөөлөх хог хаягдалыг бууруулсан байна.	Уурхайн хэмжээнд	тн	1-2 тонн багтаамжтой ялган ангилах хогийн сав	2,500,000	Жилийн турш	Хог хаягдалын тухай хууль
		Орон нутагтай хог хаягдалын гэрээ байгуулан сумын төвлөрсөн хогийн цэгт хог хаягдалыг хаяна.	Уурхайн хэмжээнд	тн		140,000	Жилийн турш	
	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдалыг дахин	Уурхайн хэмжээнд	Нэгж уулзалт		Гэрээнд заасан	Жилийн турш	

		боловсруулах, ашиглах үндэсний компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулна.				үнийн дүнгийн дагуу 400,000		
Нийт						3,040,000₮		

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

11.1. Хөрсний хяналт шинжилгээ

Уурхайн үйл ажиллагааны үр дүнд хөрсний хими, физикийн шинж чанар, хүнд металлын агууламжинд гарч болох өөрчлөлт, мөн түүнчлэн хөрсний чанар нь холбогдох стандартын шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянах зорилгоор хяналт шинжилгээтэй холбоотой доорх ажлыг 2023 онд хийхээр төлөвлөж байна

Хүснэгт 11. Хөрсний хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Хөрсний чанар-Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд	1. Уурхайн технологийн замын хажуу талаас 2. Кемпийн хашаан дотроос 3. Нүүрс цагаалсан талбайгаас	Жилд 2 удаа 6 сар, болон 11 сард	2 удаа	180,000	360,000	Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөр хийлгэнэ	MNS5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS5859:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөхөгдөх хэмжээ
	Урт хугацааны шимт, шимэрхэг хөрсний физик хими үржил шимт чанарын үзүүлэлт	Шимт хөрсний овоолго						
Нийт						360,000₮		

11.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ

Зээгтийн уурхайн талбай нь Монгол орны уур амьсгалын мужлалаар гандуу дулаан зунтай бүсийн, хүйтэн өвөлтэй мужид байрладаг. Энэ утгаараа бусад бүс нутгуудтай харьцуулахад хур тунадас бага, хуурайшилт ихтэйгээс гадна, салхины хурд өндөр байдаг буюу тоосжилт үүсэх байгалийн суурь нөхцөлтэй зэргээс агаарын чанарт үзүүлэх нөлөөг хянахын тулд дараах ажлыг төлөвлөөд байна.

Хүснэгт 12. Агаарын чанарын хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Агаарын чанар	Уурхайн талбайн 3 цэгээс	Жилд 2 удаа 6 сар, болон 11 сард	2 удаа	360,000	720,000	Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөр хийлгэнэ	MNS4585:2016 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага
Нийт						720,000		

11.3. Усны чанарын хяналт шинжилгээ

Хүснэгт 13. Усны чанарын хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Усны чанарын шинжилгээ	Уурхайн эзэмшлийн 2 худаг, мониторингийн 2 худаг, Ботгон гол	Жилд 2 удаа 6 сар, болон 11 сард	2 удаа	70,000	140,000	Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөр хийлгэнэ	MNS4585:2016 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага
Нийт						140,000		

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК-ийн Байгаль орчны баг нь Байгаль орчин , Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэст харьяалагддаг бөгөөд 2 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид энэ жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө оруулсан төлөвлөгөөт ажлуудаа сумын засаг захиргаа, байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран үр дүн чанартай зохион байгуулан ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

Зураг №4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчны хэлтсийн бүтэц орон тоо



2022 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах ажлын хэсгээс гаргасан дүгнэлт, зөвлөмжийн дагуу дараах арга хэмжээг авахаар төлөвлөөд байна.

Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөөний хэрэгжилтийг шалгарсан ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Төлөвлөсөн ажлууд	Хэрэгжүүлэх хуваарь	Зардал	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1.	Цаашид тухайн жилийн нэмэлт хайгуул болон оборлолтын ажил эхлэхээс өмнө тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан орон нутагт ирүүлсэнээр үйл ажиллагааг эхлүүлэх	Тухайн оны 1-дүгээр улиралд багтаан хүргүүлсэн байна	-	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг бэлтгэн орон нутгийн байгаль орчны мэргэжилтнүүд аймгийн байгаль орчны газрын саналыг авч холбогдох ажлууддээр хамтран ажиллахаар төлөвлөн холбогдох төлөвлөгөөг батлуулан 1-р улиралд багтаан хүргүүлсэн байна.
2.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болох газрын төлбөрийн орлогыг жил бүр хугацаанд нт барагдуулан өр авлагагүй ажиллах	Жилийн турш	-	Тухайн жилийн газрын төлбөрийг холбогдох хуваарь нэхэмжлэхийн дагуу төлөлтийг хийж ажиллана.
3.	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 2022 онд хашаалсан 1,5 га талбайн ойн зурвасын нөхөн тариалалтыг хийж арчилгаа усалгааг сайжруулах	Жилийн турш	-	Тухайн жилд 1000 ширхэг тарьц сулгац тариалан нөхөн тариалалт хийж 7 хоног бүр усалгаа хийж орон нутгийн туршлагатай мод тариалагч нартай гэрээлэн хамтран ажилласан байна.
4.	Тухайн аймаг сум орон нутагт хууль бусаар ашигт малтмал олборлолтонд өртөж эвдрэлд орж орхигдсон газрыг нөхөн сэргээх ажлыг тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний биологийн олон янзын байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөнд оруулан гүйцэтгэх (2 га-с доошгүй талбайд)	Жилийн турш		Холбогдох ажлын төлөвлөгөөнд оруулан холбогдох ажлыг гүйцэтгэсэн байна.
5.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт туссан ус агаар хөрсний шинжилгээг олборлолтыг саруудад аймгийн ус цаг уур орчны шинжилгээний төвөөр хийлгэн үр дүн анализ хийн тайлагнаж, эх хувийг уурхай дээр байлгах	Оны 1-р улирал болон 4-р улиралд холбогдох шинжилгээнүүдийг хийлгэнэ.	2,380,000	Олборлолтын үе болон нүүрс борлуулалтын үеүүдэд жилд 2 удаа шинжилгээ хийлгэж үр дүнд анализ хийж холбогдох шинжилгээний баримт бичгүүдийг уурхай дээр хадгална.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Зээгтийн уурхай 2023 он

6.	Хог хаягдалыг ангилан ялгах, дахивар хог хаягдалын гэрээ хийн хэрэгжилтийг хангах	Жилийн турш	-	Хог хаягдалыг ангилан ялгах цэг байршуулна. Мөн дахивар хог хаягдалыг нийлүүлэхээр үндэсний компаниудтай гэрээ байгуулан хамтран ажилласан байна.
7.	Ариун цэврийн байгууламжийг нүхэн жорлон, угаадасны нүх, Техникийн шаардлага стандартад заасны дагуу газрын доорх усны эх үүсвэр, хөрс, агаарыг бохирдуулахгүй хүчитгэсэн доторлогоотой, давтан ашиглах шаардлага хангасан хийц бүхий нэвчилтгүй нийтийн бие засах газрыг байгуулах	3-р улиралд багтаан хийх	-	Холбогдох шаардлагын дагуу 00-ыг шинээр хийсэн байна.
8.	Ашиглалтын талбай байршиж буй аймаг, сумын удирдлагууд болон нөлөөллийн бүсийн иргэдэд үйл ажиллагаагаа танилцуулан, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажиллах	Жилийн турш		Аймаг болон сум орон нутгийн иргэдээс ирсэн санал хүсэлтийг хүлээн авч боломжит нөхцөлөөр шийдвэрлэн ажилласан байна.
Нийт				2,360,000

Хүснэгт 14. “Байгаль орчны тэмдэглэлт ногоон” өдөрлөгүүдийг зохион байгуулж иргэд, олон нийтийн байгаль экологийн талаарх боловсрол, мэдлэг, ухамсарыг нэмэгдүүлэх

№	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүд	Хугацаа	Зардал	Арга хэмжээний цар хүрээ	Хариуцсан албан тушаалтан	Арга хэмжээ
1.	Байгаль хамгаалахтай холбоотой сургалт суртчилгааны ажлуудыг аймгийн Байгаль орчны газар, Хяргас Нуур, Завхан голын сав газрын оролцооны зөвлөлтэй хамтран зохион байгуулна.	Жилийн турш	3,000,000	Аймаг сумын хэмжээнд	Б.Дэлгэрэх, Аймаг сумын байгаль орчны байгууллага, ажилтан, Хяргас Нуур, Завхан голын сав газрын оролцооны зөвлөл	Усны өдөр, Мод тарих өдөр, Байгаль хамгаалах аян
Нийт			3,000,000			

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 15. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1.	2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг орон нутгийн захиргаанд хүргүүлэх, танилцуулах	Танилцуулга хийх	2022 оны Байгаль орчны төлөвлөгөөний биелэлт, үр дүн	2023 оны 1-р улирал	Тодорхойгүй Томилолтын зардал 1,200,000	Б.Дэлгэрэх	Чандмань сум
2.	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг танилцуулж санал авах	Танилцуулгыг хүргүүлэх	2023 онд Байгаль орчны чиглэлээр төлөвлөсөн ажлуудыг танилцуулах	2023 оны 1-дүгээр улирал	Тодорхойгүй	Б.Дэлгэрэх	Чандмань сум
3.	Тэмдэглэлт өдрүүд: Дэлхийн усны өдөр, Мод тарих үндэсний өдөр, Байгаль хамгаалах сарын аян гэх мэт тэмдэглэлт өдрүүд Чандмань сумын дунд сургуулийн сурагчдад чиглэсэн танин мэдэхүйн арга хэмжээнүүд зохион байгуулна	Үйл ажиллагааны тайлан, хамрагдсан байгууллага, оролцсон хүүхдүүдийн тоо	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр мэдлэг олгох, олон нийтийн тэмдэглэлт өдрүүдийг хамтран зохион байгуулах	Тогтсон өдрүүдэд	3,000,000	Б.Дэлгэрэх	Чандмань сум
4.	Булгийн хог хаягдлыг цэвэрлэх, хашаа хамгаалалтыг засаж сэлбэх	Үйл ажиллагааны тайлан	Уурхайн ажилтнуудыг оролцуулан цэвэрлэгээний ажлыг зохион байгуулна	Жилд 2 удаа	Дотоод зардлаар	Б.Дэлгэрэх	Чандмань сум

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Зээгтийн уурхай 2023 он

5.	Байгаль орчин болон байгаль орчны тэмдэглэлт өдрүүдтэй холбоотой мэдээ тайланг сумыны нэгдсэн группуудад мэдээллэн танилцуулах, тайлагнах	Үйл ажиллагааны тайлан	Үйл ажиллагааны цар хүрээ, зар мэдээлэл, талархалын постууд	Товлосон өдрүүдэд	Дотоод зардлаар	Б.Дэлгэрэх	Чандмань сум
5.	2023 оны БОМТ-н биелэлтийг сумын ИТХ-засаг захиргаанд тайлагнах	Танилцуулга хийх	2023 онд Байгаль орчны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлт	2023 оны 4-р улиралд	Тодорхойгүй	Б.Дэлгэрэх	Чандмань сум
6.	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь үзэж шалгах ажлын хэсгийн үзлэг шалгалт	Танилцуулга хийх	Төлөвлөгөөний агуулгын дагуу	2023 оны 4-р улиралд	Тодорхойгүй	Б.Дэлгэрэх	Чандмань сум Зээгтийн уурхай
Нийт				1,200,000			

Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн төсвийн задаргаа

№	Арга хэмжээ	Төсөв
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний төсөв	1,300,000
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний төсөв	
3.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний төсөв	5,000,000
4.	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний төсөв	
5.	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний төсөв	1,000,000
6.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төсөв	1,050,000
7.	Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний төсөв	3,040,000
8.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төсөв	1,220,000
9.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	3,000,000
10.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний төсөв	1,200,000
Нийт		16,810,000₮